

Ejee (anonym), the milk-seller in Khovd, gives interview. Taken by Irina Morozova with some Russian translation. August 2012.

- Бас хөдөлмөрлөх хэрэгтэй. Хүн одоо өөрөө л хөдөлмөрлөж чадвал амьдарч чадаж байна ш дээ. Хөдөлмөр голохгүй хийж чадвал, өөрөө одоо янз бүрийн юм сэтгээд л тийм ээ, тэгээд л ажлаад л. Жишээлбэл, би ч гэсэн одоо тэтгэвэртээ гарчихаад л зүгээр хийх юмгүй хэвтэж байхын оронд, ингээд сүү таргаа бөөндөж аваад, ганц хоёр зуун төгрөг нэмж зараад, тэгээд ямарч байсан уудаг юмныхаа, иддэг талх боовныхоо үнийг олдог. Тэгэхгүй бол ганц тэтгэвэр гэвэл, хаанаа ч хүрэхгүй ш дээ. Тэгээд би ганц бие амьдардаг. Манай нөхөр нас бараад одоо хорин хэдэн жил болж байна. Уул нь цэргийн сургууль төгссөн хүн. Хойно цэргийн академи, нөгөө Малиновскийн цэргийн танкийн академи төгссөн хүн байсан. Тэгээд өвчнөөр нас бараад, одоо 27 жил болж байна. Би энэ одоо Багшийн дээд ажиллаж байгаад. Манайхан Улаанбаатарт байж байсан. Энд 1984 онд ирсэн тэгээд л энд амьдардаг. Багшийн дээдэд бичиг, бичээч голдуу хийдэг байсан. Тэгээд л яахав тэтгэвэртээ гараад одоо 9 жил болж байна. Тэгээд яахав зүгээр байхгүй, хөдөөнөөс ирсэн улсаас сүү аваад, сүүгээ зараад, сүүгээ боловсруулж тараг хийгээд ингээд зараад одоо яахав... одоо бол өвчнөө бодоод гэртээ хэвтээд байвал. Би чинь саахарын өвчтэй, даралт ихдэнэ. Гэртээд хэвтээд байвал хүнд бол хэцүү. Одоо энд гарсаар бас агаарт байна. Сүү хүнд өгвөл өглөө эрт гарна. Иймэрхүү л байна даа. Өөр юу ярих вэ.

(Interpreter: сейчас она одна живёт. 20 лет тому назад её муж умер. Её муж в Российской окончил Военный университет и от болезни он умер. Сейчас она живёт на пенсий.

- Получается, он умер 1992 году, да?

- Да. 1984 году они приехали из Улаанбаатар сюда. И она работала в Ховдском Гос-Университете "typist"-ом. И она сейчас продает молоко, потому что ей трудно жить только за счёт пенсий. Поэтому она занимается этим бизнесом.

- А в каком году она родилась и где?

- Та хэдэн онд, хаана төрсөн бэ?

- Би 53 онд яг энэ Ховд аймгийн Жаргалан багийн тэнд. 1953 оны 3-р сарын 7-нд төрсөн. Тэр үед Сталин нас барсан гэж манай ээж тэгж хэлж байсан. Манай ээж 95 нас хүрээд энэ өвөл Улаанбаатарт нас барсан. Бид чинь бас оросоор ярина ш дээ. Орос хэл чинь англи хэлний хажууд бол бас аягүй мэдэж байна ш дээ. Чөлөөтэй ярихгүй ч гэсэн орос хэл сургуульд үзэж байсан болохоор ганц хоёр үгийг мэдэж байна.

- Та Сталины тухай юу гэж боддог вэ?

- Би мэдэхгүй ээ тэрийг зүгээр. Манай ээж ийм өдөр нас барсан гэж л хэлж байсан.

- Жинхэнэ одоо манайхны лам нар хуврага нарыг устгасан анхны тушаал өгсөн хүн бол Сталин гэж монголчууд ойлгодог, тэрийг ч номон дээр бичсэн байдаг байхгүй юу. Сталинд бол миний үеийнхийн бол тийм нэг сайн биш. Манай Цэдэнбал хүртэл орос очоод юу яасан учир... өөрөөр хэлбэл, их сайн байсаан орос ах нар гээд бид оросыг их хүндэлдэг байсан. Жирийн найз нөхдийг бид нар хүндлэлгүй яахав. Зүгээр ер нь хоёр том нугалаа гаргасан байхгүй. Тэр нугалаа нь юу юм гэхлээр, нэгдүгээрт, Сталин лам нарыг хоморголон устгаж, амьдаар нь шороонд булж байсан. Тушаал өгч дээрээс нь. Өөрөөр хэлбэл, шарын шашинтныг бүгдийг одоо дарж авахгүй л болбол наадах чинь хэзээ ч монголын толгойг эргүүлээд манай номонд орж өгөхгүй гэдэг ийм зарчмаар. Би багш хүн байна. **(Another woman came and said: ей 71 лет, она была учительницей.)**

- Чойбалсангийн талаар та юу гэж бодож байна вэ ? /Mogozova/

- Чойбалсан Сталингийн баруун гар. Манай Цэдэнбал бол бас их оросын хүргэн болоод сүүлдээ болбол Цэдэнбалыг маш муугаар дарангуйлсан. Бид Цэдэнбалд маш их хайртай. Я люблю тебя Цэдэнбала. Олон жил төр барисан, төрийг одоо сайхан болголоо. Нэг нутгийнх. Нутаг биш ч гэлээ төрийн толгойд олон жил байсан. Увс аймгийнх.

- Наад хүн чинь хаанаас ирсэн бэ?

- Германы Хумбольдын их сургуулиас ирсэн. Тэнд ажилладаг хүн байхгүй юу. Тэгээд судалгаагаар энд ирж байгаа юм.

- Дом где, где живёте?

- Берлинд ажилладаг. Зүүн Берлин, Баруун Берлин биш.

- Би старуха 71 настай. Одоо 72 хүрч байна.

- Нет, вы не старуха.
- Ямар байна, орос германы эмээчүүдээс ямар байна?
- По сравнению с германскими бабушками как она выглядит?
- А вы очень энергичны и бодры, поэтому старухой вас назвать не возможно. Вы смеётесь очень весело, гораздо больше, чем берлинские женщины вашего возраста.
- Берлинд таны насны хүмүүс ингэж инээж цоглог байдаггүй гэж байна ш дээ.
- Өө, уурлаад байх уу. Бид үхтлээ бүжиглэнэ ш дээ. Тийм учраас жаахан цоглог байж болох юм.
- **Эгч нөгөө Ховдын оюутнууд ардчилсан хувьсгал болоод тэр үед чухам юу болсон бэ?**
- Юу болхов дээ. Тэр үед нийгмийн багш нар Сараа багш байсан. За байз өөр чинь хэн хэн билээ дээ. Одоо нөгөө Батцоож багш байсан байх аа... одоо хотод байна. Хэн хэн билээ дээ...нилээд хэдэн багш байсан. Залуу багш нар удирдаад, оюутны байрьнаас сандал ширээ, лоозун бариад энд талбай дээр жагсаж байсан. Тэгээд л ямар юм болох юм бол, нийгмээ өөрчөлье, яая гэж тэр үед ярьж байсан юм байлгүй дээ.
- **Тэгээд тэр үед ардчилсан хувьсгал болж байхад та хэд юу гэж бодож байсан бэ?**
- Юу гэж бодох вээ дээ, манайхны зарим нь уурлаад, манай проректор Сайнбилэг энэ залуучууд арай дэндлээ зүгээр, буудан алах байлгүй дээ гэж байсан. Ер нь тэд нарыг дэмжихээсээ илүү дэмжихгүй талдаа байсан чинь.
- (**Interpreter:** во время студенческой демонстраций, проректор Сайнбилэг говорил, что студенты слишком плохо ведут себя. Ну можно их стрелять. Другие также говорили. Молодые преподаватели были вождём демонстрации.)
- **А она знала этих молодых людей?**
- **Да, она знает некоторых.**
- **Спросите что за люди, и почему они пришли так выступить, как они пришли к этой идее, как она родилась?**
- Тэрийг залуу багш нар удирдсан гэсэн ш дээ. Тэр залуу багш нар ямар учраас тэр ардчилсан жагсаал хийж тэгэх болсон юм бэ?

- Одоо яахав, тэд нар нийгмийн багш нар байсан ш дээ. Бодвол нийгмээ л харж байсан юм байлгүй дээ.
- ***Тэд нар тэр жагсаал хийх санааг, ардчиллын ойлголтыг хаанаас олж авсан юм бол?***
- Хэн мэдхэв дээ. Хотын хүүхдүүд байсан ш дээ. Хотоос л ирсэн байх.
- **Interpreter:** она тоже не знает. Она сейчас собирается домой. Ещё придёт.
- ***Ну, завтра она, наверно, как говорит, я имею в виду, что она придёт или сегодня?***
- ***Таньтай маргааш бас уулзаж ярилцаж болох уу?***
- Би өглөө 6-12 цаг хүртэл байдаг, орой нэг сууна. Тэгээд л болоо.
- ***Аа... с утра до 12 она будет здесь на работу.***
- ***Ну, посмотрим, может быть, зайдём завтра тоже к ней. Хорошо, еще поговорим.***
- ***Значит сейчас мы уйдём или ещё ждать ?***
- ***А она сейчас сюда придёт ? Аа... я думаю, что можно подождать, почему бы нет. Потому что есть результат.***

- :- **Interpreter:** Большинство из этих преподавателей были преподаватели обществоведения. Поэтому они знали лучше такое построение общество. Наверно они об этом знали из Улаанбаатара. Потому что они кончили университет в Улаанбаатаре и потом пришли сюда, приехали работать. Поэтому они так думали и организовывали демонстрацию.
- :- Морозова: Интересно. Да вот ...бедная женщина...

- **Interpreter:** определённое время начинает работу и определённое время кончает работу. Большинство людей были определённые, однотонные работы. Когда начинается демократизация, в демократическом обществе у них жизнь стала немножко труднее, но с другой стороны другие многие возможности открываются. Кто много работает, те лучше зарабатывают в демократическом обществе. Она так говорит.

- *А вот, что Вы думаете об этом: не надо быть ленивым, работаете, будете лучше зарабатывать. Ну вот вы лично что думаете об этом?*
- Я лично тоже так думаю. Ну люди говорят сейчас очень много специальности, но без работы сидят и говорят не найдётся работа. Ну с другой стороны, у нас есть возможность сам себя сделать работу.
- *Аа... это да у кого-то есть, но те у кого нет, если человеку не повезло, человек пенсионер или инвалид. То что тогда?*
- Да...
- *Вот... его не возможно винить в том, что он ленивый, но таких очень много. Вот она живёт и продает молоко, вот здесь стоит, чтобы купить себе инсулин.*
- Ну она, чтобы купить инсулин, её пенсия не хватает. Поэтому она решила продавать молоко.
- *А вот... что же делать, вы видите? Это... общество, оно дает возможности не всем. Некоторым определённым классам.*
- В этом случай это зависит от человека лично.
- *Ну, вот не всегда. В её случае, она, может, очень трудолюбива, всё что угодно. Но у неё нет возможности, она живёт в свободном обществе. Но она не может. И есть, например, возможность ехать зарубеж, хорошо прекрасно. Но если у тебя нет денег, ты не поедешь никуда. И вот то, что меня возмущает в нарративе многих монгольских интеллигентов, когда они говорят об этой перемене, о том, что свобода была, что те, кто много работал, стал много получать. Но как будто они забывают о всех других, которые существуют. ... Вот это мне возмущает. Не в её случае, нет. А в случае именно интеллигентов. Потому что это их история, это их версия. Она её, как другие.., услышала и по своему передает.*
- *Это молоко или кумыс?*
- *Расскажите, пожалуйста, поподробнее, как у вас здесь было в 1989 году вот... неужели же вот эти преподаватели молодые, которые пошли на забастовку, неужели действительно кто-то их*

притеснял? Ну вот создавать какие-то неблагоприятные условия, запрещать там выражать своё мнение и так далее...

- *Ардчилсан хувьсгалын үед тэр жагсаал цуглаан зохион байгуулсан багш нарыг одоо ямар нэгэн сөрөг арга хэмжээ авсан болов уу?*

Шийтгэх ч юмуу?

- Шийтгээгүй байх аа. Нээх арга хэмжээ аваагүй байх аа.

- **Interpreter:** Она точно не знает. Не трогали их.

- *А кто тогда вот, всё таки когда они выступили, кто сказал, что их надо расстрелять?*

- Аа тэр нөгөө проректор бас тэр хүн, буудчих юм сан гэж хэлсэн тийм ээ?

- А тэр яахав. Тэгэхдээ эндих улсуудыг хэлээгүй ээ. Тэр чинь Улаанбаатарт нөгөө өлсгөлөн зарлаж байсан чинь. Одоо нөгөө Элбэгдорж, Гончигдорж, Зориг тэр хэдийг хэлж байсан байхгүй юу. Хурал болсон чинь зурагтаар гарч байсан, Засгийн газрыг огцор барь гээд л. Тэгээд Батмөнх чинь бууж өгсөн ш дээ. Ерөөсөө ширээгээ тавьж өгөөд л..тэр үед тэрийг л...

- **Interpreter:** Она говорит в Улаанбаатаре люди которые организовали демократическая демонстрация такие как Элбэгдорж, Гончигдорж вожди их называли так. Они посмотрели по телевизору и она говорила что... они требовали Ж.Батмөнх чтобы он дал им свое правительство. Она была против этого, сказали, можно их стрелять.

- *А кто против этого сказал стрелять, кто, кто... ?*

- А это был проректор.

- *А его много тогда поддержали, кто поддержал его, кто с ним не согласился ?*

- Өөр тэрнээс гадна, тэр хүнтэй адилхан тэр хүмүүсийг эсэргүүцэж, буудах юмсан гэсэн хүн байсан уу?

- Байхгүй, байхгүй. Байхгүй л байсан байх аа, мэдэхгүй ээ. Зарим нь дургүйцээд л, зарим нь гайхаад л. Нээх дэмждэг хүн ч байсан юм уу даа, эхлээд ойлгохгүй л байсан байхгүй юу.

- **Interpreter:** сначала большинство людей не поняли, что такое демократизация, и очень сомневались, это плохо или хорошо. И по её мнению, большинство людей плохо относились к демократизации.

- ***А какое было её отношение, что она делала в этот период, вот как её жизнь складывалась?***
- Танай гэр бүлийн хувьд, эгч яг тэр нөгөө ардчилсан шилжилт, өөрчлөн байгуулалт болоод шилжилт болсон ш дээ. Тэр үеэр та ямархуу байдалтай амьдарч байсан бэ ? Тэр үеэр юу гэж бодсон бэ ...яг картын үеэр?
- Тэр үеэр яахав дээ тэгээд одоо нээх сайн ч биш муу ч биш дундаж. Яг тэр ардчилсан хувьсгалын үеэр манай хүн ч нас барчихлаа. Би ч өөрөө өвчтэй үлдсэн. Амьдрал нэг дундаж л байсан ш дээ. Юм юм жаахан ховордуу. Мах сах бүх юм, хүнсний юм чинь картанд байсан ш дээ. Одоо бол яахав мөнгөтэй л бол бүх юм элбэг дэлбэг байна.
- **Interpreter:** как только... в это время её муж умер. Её жизнь была в среднем уровне. Не так хорошо, не так плохо. Вещи стали редкие. Но их жизнь была в среднем уровне.
- ***Но он же умер 1992 году. То есть 1989-1990 году он всё ещё был жив. Он какую позицию занимал вот по этому вопросу её муж?***
- Тэгэхээр тухайн үедээ танай хүн 1989 оны үед энэ талаар юу гэж бодож байсан юм бол, ардчилсан хувьсгалын талаар?
- Манай хүн ерөөсөө сайн ч юм хэлээгүй, муу ч юм хэлээгүй, гайхаад л байсан. Сайныг ч мэдэхгүй, муугийн ч мэдэхгүй, гайхаж байсан.
- **Interpreter:** он тоже удивлялся, не так хорошо, не так плохо относился. Просто не понял, сомневался в этом.
- ***А вот что было в Университете..? вот после того, как здесь произошли эти события, потом ещё были здесь демонстрация, но вот в Улаанбаатаре в основном были демонстраци. А здесь в Ховде?***
- Тэр жагсаал болсны дараа хотод нэг жагсаал болсон гэсэн. Тэгээд манай Ховдод тэр жагсаалаас өөр дахиж жагсаал болсон юм болов уу ? Ернь юу болсон юм бол?
- Жагсаал болоогүй байх аа. Сайн мэдэхгүй.
- Тэр хотод болсон жагсаалыг дэмжиж Ховдод энэ хавиар хүмүүс ярьж байв уу.
- Үгүй. Ер нь манай Ховдод эхэлж жагсаал болсон юм биш үү.

- Тийм гэсэн харин. Тэр чинь анхных нь байсан гэсэн ш дээ.
- Үнэхээр би гал зууханд байж байхад цонхоор харж байхад хүүхдүүд баахан юм бариад л орилдоод байсан. Оюутнууд явж байсан гэсэн.
- **Interpreter:** После этого здесь не было демонстрации. По её мнению, это была первая демонстрация в Монголии.
- ***Почему больше ничего здесь не происходило? Она одна так первая случилась и потом уже ничего не была. Почему так?***
- Тэгээд одоо тэр жагсаалын дараа яагаад дахиад жагсаал болоогүй юм бол?
- Ёстой мэдэхгүй. Тэрийг сайн мэдэхгүй байна.
- **Interpreter:** она не знает.
- ***А как вот она... тогда какие ходили разговоры, вот о том, что происходит в Улаанбаатаре, и что требует отставку правительства Батмунха, а как это обсуждалась в городе?***
- Тэгээд тэр Улаанбаатарт жагсаал болоод Батмөнх дарга засгийн газраа өгж байсан. Тэрний талаар энэ хавиар хүмүүс юу гэж ярьж байсан бэ?
- Ёстой мэдэхгүй. Зарим нь дэмжээд, зарим нь дургүй л байсан байх. Дэмжиж байсан нь ховор байсан. Зарим нь ч яахав зөв шийдвэр гаргаж байна, дайн байлдаан болоогүй, тайван аргаар явагдлаа гэж. Зарим нь болохоор одоо ямар сонин юм гээд л. Нэг талаас бас Батмөнхийг дэмжиж байсан хүмүүс байсан байх аа. Зөв шийдвэр гаргалаа гэлээ энэ хүн. Тэгэхгүй бол энэ чинь бас дайн гарчвал юу магад.
- **Interpreter:** некоторые поддержали. С одной стороны некоторые поддержали Батмунх. Потому что говорят это мирным путём решили проблемы, а то может быть начнётся гражданская война. Поэтому некоторые люди думали он хорошо решил. Но большинстве людей были против этого.
- ***А откуда поставки идут, вот её молочных продуктов, - из худона привозят?***
- **Interpreter:** Из худона скотоводы привозят. Она по дешевле покупает и ещё прибавляет некоторые деньги и сама продает.
- ***Понятно.***

- **Interpreter:** можно вставать рано утром 5 или 6 часов чтобы купить молоко из скотоводов.
- ***Она встает каждый день в 5-6 утра. Они сюда привозят, да? И потом весь день продает или вечером.***
- **Interpreter:** С утра до 12. И потом вечером.
- ***Как долго у неё бизнес?***
- Та одоо хэдэн оноос эхэлж ажиллаж байна?
- Би одоо 10-аад жил болж байна. Тэтгэвэртээ гараад л.
- **Interpreter:** 10 лет работает, после пенсии.
- ***А, то есть, она ушла только в 2000 году на пенсию, да? А как 90-ые годы она помнит, - конечно, тяжело было? А как она выживала в 90-ые год ?***
- 90-ээд оны үед та хэрхэн амьдарч байсан бэ эгч? Амьдрал хэцүү байв уу, ямар байв?
- Хэцүү байлаа. Би чинь өвчтэй. Манай нөхөр нас барсан. Зах зээл эхэлсэн. Юм хумны үнэ нэмэгдээд, хүүхэд шуухад бага, сургууль, оюутан байсан.
- **Interpreter:** очень трудно было. Дети маленькие, учились в университете. Она сама больная.
- ***А сколько у неё детей ?***
- Та хэдэн хүүхэдтэй вэ, эгч ээ ?
- 4 хүүхэдтэй. Нэг охин, нэг хүүтэй.
- **Interpreter:** Четыре.
- ***А сейчас они кем работают, на кого выучились?***
- Танай хүүхдүүд ямар ямар мэргэжилтэй вэ, хаана ажиллаж байгаа вэ, эгч ээ?
- Яахав гайгүй мэргэжилтэй л дээ. Тэгэхдээ ажил мажил бас жаахан тиймэрхүү л байна. Том охин урлагийн сургууль төгссөн юм. Гэхдээ урлагийн ажил хийгээгүй, зүгээр өөр ажил хийж байгаа. Дараачийн охин хоёр ч дээд сургуульд сурдаг, тэгээд гэртээ хүүхдээ харж байгаа. Бага охин бас нялх хүүхэдтэй, бас дээд сургуульд төгссөн. Том залуу эдийн засагч. Банкинд ажиллаж байсан. Ажлаа өөрчлөөд, бас бие нь өвдөөд, ажлаа өөрчилсөн. За яахав дээ нэг үеэ болдвол бүгдээрээ том болсон.

Аавыгаа нас бархад том нь 8-р анги төгсөж байлуу даа. Бага нь 4 настай байсан.

- **Interpreter:** когда умер папа старший сын учился 8-ом классе, младшему было 4 годика. А сейчас сын работает экономистом. В банке работает. А дочь училась искусствоведом. Следующее дочь без работы, с ребёнком дома сидит. Самая младшая дочь учиться в Университете.
- Одоо тэгээд юм бичихгээд байгаа юм?
- Нөгөө нэг судалгааны ажил юм л даа. Манай оронд ардчилал яаж үүсч хөгжсөн, одоо ямар шатанд явж байгаа, хүн ардын амьдрал ардчилал гараад ямар байна тэр талаар.
- Одоо яахав дээ хөдөлмөрлөж чадвал, амьдарч чадаж байна ш дээ. Янз бүрийн юм эхлээд л... хувиараа ч гэсэн. Улсын ажилчгүй ч гэсэн хувиараа сэтгээд юм хийсэн улсууд бас чадаж байна шүү.
- **Interpreter:** сейчас люди, которые не имеют государственную работу, должны заниматься своим бизнесом, можно жить. Если человек хочет, может делать любые дела. Можно зарабатывать.
- **Какой был самый хороший период в её жизни, который она вспоминает?**
- Таны амьдралд хамгийн амар хялбар сайхан байсан үе аль үе вэ?
- Гүй одоо социалист нийгэм үе байсан юм болов уу. Тэгэхэд чинь бас амар байсан л даа. Ажлаа хийчихээд илүү дутах бодож санах юмгүй. Мэдэхгүй ээ.
- **Interpreter:** Она думает, что при социализме было нормально. Но при социализме тоже имеет плохие стороны. Но в то время было нормальным. Безработица была мало, государство определяли люди на работу. Присылают людей на определённые места и люди работали.
- **А её ученики к ней приходят?**
- Та багш байсан уу?
- Би бичээч байсан.
- **Interpreter:** она была писателем.
- **Что вы писали, расскажите?**
- Юу бичдэг байсан бэ, бичээч гэхээр?

- Одоо яахав бичиг хэргийн янз бүрийн юм л бичнэ шүү дээ. Захиргааны бичиг хэрэг, тушаал гээд л...
- **Interpreter:** она писала указы директора, проректора такие административные документы.
- ***А литературные произведения она не писала, стихи, рассказы ?***
- Та ямар нэг уран зохиолын төрөл болох шүлэг ч юмуу ямар нэгэн юм өөрөө бичдэг байсан уу ?
- Үгүй.
- ***Понятно. Спасибо большое. Завтра мы ещё, может быть, придём чтобы фотографировать Вас. Это вот Вам с России шоколад. Действительно русский шоколад, не китайский.***